

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН

УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА...../А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ТАХЬ РЕСУРС”ХХК - ИЙН ЗАХИРАЛ/Д.ЭНХМАА/

БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНЛИГ, БОГД,
ДЭЛГЭРХАНГАЙ, САЙХАН-ОВОО, БАРУУНБАЯН-УЛААН, БАЯНГОЛ, БОГД, ГУЧИН-УС,
НАРИЙНТЭЭЛ, САНТ, ТАРАГТ, ТӨГРӨГ, ХАЙРХАНДУЛААН, МАНДАЛ-ОВОО СУМДЫН
НУТАГТ ОРШИХ “**ОНГИ V**” ТАЛБАЙД 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Уламжлалт бус газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар: 679/

/Регистрийн дугаар: 5513618/

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ...../ Б.Батбаяр /

2023 оны сарын

Боловсруулсан:

“Тахь ресурс” ХХК-ийн геологич/ Т. Гансүх/

2023 оны сарын

Улаанбаатар 2023 он

Агуулга

1. Төслийн танилцуулга	2
1.1 Хайгуулын ажлын арга, аргачлал	5
1.2 Ажилчдын тоо, ажиллах горим	10
1.3 Усны эх үүсвэр ба ус хэрэглээ	10
1.4 Химийн бодисын хэрэглээ	12
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	12
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	15
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	16
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
11. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	24
12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	26
13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29
16. Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал	30

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Тахь ресурс” ХХК нь НДМХ Онги V блокын хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт малтмал, Газрын тосны Газар болон Тахь ресурс ХХК-ийн хооронд 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр НДМХ хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа гүйцэтгэхээр “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан. 2021 оны 6 сарын 18-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хайгуулын тусгай зөвшөөрлөө аван хайгуулын ажлаа эхлүүлээд явж байна.


“Тахь ресурс” ХХК нь шинэ эрчим хүчний эх үүсвэр НДМХ хайгуул судалгааны ажлыг шат дараалалтай явуулж, эдийн засгийн хувьд ач холбогдолтой хэтийн төлөв бүхий метан хийн нөөцийг олж илрүүлэх зорилготой.

Монгол улс нь байгалийн хийн нөөц илрэх бүрэн бололцоотой газар нутаг бөгөөд метан хийн хэтийн төлөв бүхий нөөц баялгийг олж илрүүлснээр эрчим хүчний хувьд 2 хөршөөс хараат бус болох, хямд үнэтэй шатахуун дотооддоо үйлдвэрлэх, хотуудын агаарын бохирдлын асуудлыг шийдэх, шинэ ажлын байр болон эрүүл аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх мөн эдийн засгийн хувьд тогтвортой орлогын шинэ эх үүсвэртэй болох гэх мэт эерэг нөлөөтэй.

Тахь ресурс ХХК нь НДМХ-ийн Онги-V хайгуулын талбайд 2022 онд Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулж батлуулсан боловч тухайн оныхоо тайлант хугацаанд геологи хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.

2023 онд Тахь Ресурс ХХК нь чөмгөн дээжтэй алмазан хошуут өрөмдлөгийн дахин хоёр цооногийг нийт 1200 тууш метр өрөмдөж, өрөмдсөн цооногууддаа дагалдах дээжлэлт, лабораторийн ажил, геологи, геофизик, цооногийн туршилтын ажлуудыг төлөвлөсөн.


Хайгуулын ажлын хөтөлбөрт өрөмдлөгийн ажил, цооногийн геофизикийн судалгаа, дээжлэлт, лабораторийн шинжилгээ зэрэг геологи хайгуулын ажилтай холбоотой ажлын чиглэл, төрөл, тоо хэмжээ тодорхойлох, геологийн ба байр зүйн зургуудыг бэлтгэх, олшруулах зэрэг бэлтгэл ажлуудыг хамрууллаа. Мөн хайгуулын ажлын төсөв, төлөвлөгөөг боловсруулж холбогдох төрийн байгууллагаар батлуулах, мөн гэрээлэгч байгууллагаар гүйцэтгүүлэх ажлуудад гэрээт гүйцэтгэгч олж гэрээ, хэлцэл байгуулах, эрэл хайгуулын ажилд шаардлагатай материалыг худалдан авах, бэлтгэх зэрэг ажлууд хийхээр төлөвлөсөн.



Зураг 1. Онги-V талбайн байршлийн зураг

Хүснэгт 3. Онги V блокгийн талбайд хамарах аймаг, сумд

Д/д	Хот, аймаг	Эзлэх талбай(Га)	Сум, дүүрэг	Эзлэх талбай(Га)
1	Баянхонгор	6522.58	Баянлиг	2533.51
2			Богд	3989.07
3	Дундговь	128104.48	Дэлгэрхангай	5985.16
4			Сайхан-Овоо	122119.32
5	Өвөрхангай	1934237.06	Баруунбаянулаан	202778.29
6			Баянгол	201930.37
7			Богд	279592.23
8			Гучин-Ус	461921.21
9			Нарийнтээл	74451.12
10			Сант	7578.69
11			Тарагт	31008.13
12			Төгрөг	478751.24
13			Хайрхандулаан	196225.78
14	Өмнөговь	45471.84	Мандал-Овоо	45471.84



Зураг 2. Онги-V талбайн булангийн цэгүүдийг харуулсан зураг

Хүснэгт 2. Онги V блокын булангийн цэгүүдийн координат

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	2	3	4	5	6	7
1	104	9	59.04	45	19	59.88
2	104	9	59.04	45	10	0.12
3	104	0	0	45	10	0.12
4	104	0	0	45	0	0
5	102	39	59.04	45	0	0
6	102	39	59.04	44	40	0.12
7	101	30	0	44	40	0.12
8	101	30	0	45	49	59.88
9	103	51	8.64	45	49	59.88
10	103	51	8.64	45	19	59.88

1.1 Хайгуулын ажлын арга, аргачлал

ЧӨМГӨН ДЭЭЖТЭЙ АЛМАЗАН ХОШУУТ ӨРӨМДЛӨГ

Дээр дурдсан хийн-цохилтот өрөмдлөгийн үр дүнд метан хий байж шалгуур шинж тэмдэг илэрч, метан хий байж болох тохиромжит гүнд нүүрст давхраас тогтоогдвол, чөмгөн дээжит алмаазан хошуут өрөмдлөгийн аргаар дахин нэг цооног өрөмдөнө.

Энэхүү цооногийг өрөмдөх гол зорилго нь нүүрсний давхаргаас өндөр чанартай чөмгөн дээж авах, сонгосон инвервалын дээжийг ашиглан тухайн ордын хийн агууламж, шинж чанарыг тодорхойлох юм.

Нүүрсний давхаргын метан хийн эрлийн болон десорпц тест хийх цооногийг өрөмдөхдөө Австрали болон Америкийн СВМ өрөмдлөгийн стандартыг баримталж өрөмдөнө. Тухайн өрөмдлөгийн онцлог нь:

1. Цооногийн тогтвортой байдлыг дээд зэргээр хангаж явах
2. Эрдэсийн онцлогоос шалтгаалан чөмгөн дээжинд өрөмдлөгийн явцын нөлөөллийг боломжит доод түвшинд барих
3. Нүүрсний давхаргаас чөмгөн дээжний гарцыг хамгийн дээд боломжит дээд түвшинд байлгах

Өрөмдлөгийн ажлын баримтжуулалтыг барууны орны аргачлал болон Монгол улсад мөрдөгдөж буй хайгуулын арга аргачлал, заавар журмын дагуу бүрдүүлж анхдагч баримт материал, фото зураг зэргээр баталгаажуулан тусгай сан үүсгэн хадгална. Өрөмдлөгийн ажлын зардалд өрөмдлөгийн ажилтай холбоотой тээврийн зардал болон өрөмдлөгийн компаний хайгуулын кемпийн зардал багтсан болно.

НҮҮРСНИЙ СОРЬЦЛОЛТЫН АРГАЧЛАЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Хэрэв Онги V талбайд нүүрст давхраас илэрсэн тохиолдолд нүүрсний чанарын үзүүлэлт судлах зорилгоор дараах сорьцолтуудыг хийхээр төлөвлөлөө.

Нунтаг сорьц

Хийн цохилтот урвуу үлээлгэт өрөмдлөгөөс гарсан нунтаг дээжийг 1.0 метр тутмаас зориулалтын шигшүүр ашиглан сорьцолно. Нунтаг дээжийг авахдаа аль болох бохирдолыг бага байлгах зорилгоор шигшүүр дээр 2-3 удаа усаар угааж, геологийн баримтжуулалт бичиглэлийг аль болох хурдан хийж, жигнээд зориулалтын бортогонд битүүмжилж хийснээр тээвэрлэхэд бэлэн болно.

Сорьц тээвэрлэхийн өмнө сорьц илгээх маягтад цооногийн дугаар, сорьцын дугаар, сорьцолсон интервал, анхдагч жин зэргийг тусгаж өгнө.

Нүүрсний чөмгөн сорьцолт

Нүүрсний давхраасын чөмгөн сорьцлолтыг зохих стандартын дагуу авч хийн агуулгыг тодорхойлох Q₁-Q₃ хэмжилт болон нүүрсний чанарын бүрэн шинжилгээ хийлгэнэ.

ЦООНОГИЙН ГЕОФИЗИКИЙН СУДАЛГАА (КАРОТАЖ)

Цооногийн геофизикийн судалгаа нь өрөмдлөгийн ажлын үр дүнг баталгаажуулах үндсэн зорилготой хийгддэг геофизикийн судалгааны арга юм. Бид Онги V талбайд өрөмдөгдөх нүүрсний хайгуулын цооногт нүүрсний үеүдийн зузаан тэдгээрийн чулуулгуудтай хиллэж байгаа хил заагийг тогтоох зорилгоор дараах аргачлалуудыг хийж гүйцэтгэнэ.

Цооногийн геофизикийн судалгааны ажлын хүрээнд цооногийн хананы физик шинж чанарыг тодорхойлох Цооногийн геофизикийн багц-1 бичиглэлийн ажил буюу чулуулгийн цацраг идэвхийн гамма (gamma), нягт (density буюу гамма-гамма), цахилгаан эсэргүүцэл (resistivity), хазайлт (deviation), цооногийн голч буюу кавернометр (caliper) зэрэг аргачлалуудаар хийж гүйцэтгэнэ.

Мөн цооногийн геохананы бүрэн дүрсжүүлэлт, цооногийн ханандах чулуулгийн структурийн элемент, цавшилт, нуралтыг үзүүлэх цооногийн геофизикийн багц-2 бичиглэлийн ажлуудлыг хийлгэхээр төлөвлөлөө.

Геофизикийн бичлэгийн хэлбэр дүрсийг стандартчилах, нягтын судалгаанд үзүүлэх цооногийн яндан дотор ус чийгийн нөлөөг тодохойлох зорилгоор зарим эцсийн боловсруулалтыг WellCad, Well Manager программууд дээр хийнэ.

ЦООНОГИЙН ГЕОФИЗИКИЙН БАГЦ-1 СУДАЛГААНЫ ТУХАЙ

Нягт

Нягт (DENSITY) хэмжигч нь өөртөө цацраг идэвхит бодисын үүсгүүртэй бөгөөд цацруулж буй гамма долгион нь цооногийн хананаас эргэж ойх шинжийг нь бүртгэн авч, үзүүлэлтийг нь тодорхойлдог. Нүүрсний үе давхаргууд нь бусад агуулагч чулууллагуудаасаа нягтаараа эрс ялгардаг байдал нь энэхүү аргыг хэрэглэх үндэс болдог. Хол болон ойр зайтай хос мэдрэгчтэй энэ арга нь чулуулаг болон нүүрсний үе давхаргыг босоо зүсэлтийн дагуу чулуулгуудыг нягтаар нь ялгахад зориулагдсан арга юм. Нягтрал багатай нүүрсийг денсити багажаар тодорхойлоход хялбар бөгөөд нягтралын жинхэнэ чанар нь үнсний агууламжийн үзүүлэлт юм. Нягт хэмжих аргачлалын үед цооногийн нуралт үүсэж хэмжээ томорсон хэсэг нь хэмжилтийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг учир цооногийн диаметр хэмжигч багажийг давхар цогц болгон ашигладаг.

Гамма

Гамма (GAMMA) хэмжилтийн багаж чулуулгаас ялгарах байгалийн гамма цацрагийг хэмждэг. Гамма цацраг нь маш өндөр давтамжтай цахилгаан-соронзон долгион бөгөөд олон төрлийн элементийн задралын дүнд үүснэ. Цооног дахь цацраг нь ерөнхийдөө кали, тори, уран зэрэг элементийн цацраг-идэвхит изотопиос үүсдэг.

Гамма аргаар цооногийн ханын дагуу байрлах чулуулгийн байгалийн цацраг идэвхжилтийг тодорхойлдог ба хэмжих нэгж нь API болон мкр/Цаг байдаг. Нүүрсний үе давхаргууд нь бусад үе давхарга болон агуулагч чулуулгуудаас гамма идэвхит шинж чанраараа эрс ялгаатай буюу бага байдаг бөгөөд энэ шинж чанраар нь нүүрсний үе давхаргуудыг ялгадаг. Тус аргачлалыг нүүрсний орд газар дээр өрөмдсөн цооногт нүүрсний үе давхаргын зузаан болон бусад чулуулгуудын хил заагийг тогтооход цооногийн геофизикийн судалгааны бусад аргуудтай хослон хэргэлэдэг. Байгалийн Гамма аргачлалаар нүүрсний үеийн үнжилттэй холбоотой шинж чанарыг тодорхойлдог. Үнслэг болон шаварлаг агууламж ихэссэн мөн өгөршисөн нүүрсний үе давхаргууд дээр байгалийн радио ивэхит шинж чанар нь нэмэгддэг тул эсрэг анимали буюу гамма аргачлал өндөр анимали үзүүлдэг.

Эсэргүүцэл

Нүүрсний үе давхарга нь агуулагч болон бусад чулуулагаас цахилгаан эсэргүүцэлээрээ эрс ялгаатай байдаг. Энэ шинж чанарыг нь ашиглаж тухайн аргыг сонгож хэрэглэсэн. Эсэргүүцлийн аргаар хэмжилт хийх үед өрөмдлөгийн цооног усаар дүүргэгдсэн байх шаардлагатай. Энэ арга нь чулуулгийн хил заагийг тогтооход иж бүрэн судалгааны арга болдог.

Цооногийн нурал тодорхойлох арга

Цооногийн босоо зүсэлтийн дагуу диаметрийн өөрчлөлтийг тогтооход зориулагдсан арга. Энэ аргаар цооногийн нуралт үүссэн хэсгийг олж илрүүлэх нягтын аргачлалын үр дүнг давхар баталгаажуулна. Ер нь нягт хэмжигч гамма – гамма багаж нь цооногийн диаметрийн өөрчлөлтөнд маш мэдрэмтгий учраас цооногт нуралт үүсэж диаметр томорсон хэсэгт өндөр заах эрсдэлтэй байдаг. Диаметр хэмжигч нь цооногийн хана нуран хөндий орон зай үүссэн хэсгийг тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг.

ЦООНОГИЙН ГЕОФИЗИКИЙН БАГЦ-2 СУДАЛГААНЫ ТУХАЙ

Каротажийн ажлынх арга аргачлалд дурдсанаар цооногийн геофизикийн багц-2 судалгаа нь хананы бүрэн дүрсжүүлэлтийг 360 градусаар дүрсэнд буулгадаг. Ингэхдээ цооногийн ханандах чулуулгийн структурийн элемент, цавшилт, нуралт, үелэл, үеийн

чиглэл, литологийн дүн шинжилгээ, стратиграфийн шинжилгээ, цооногийн диаметр гэх зэрэг олон үзүүлэлтийг үзүүлдэгээр нүүрсний давхаргын хийн алдагдагдал зэрэг үзүүлэлтүүдэд ашиглах боломжтой.

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ

Нүүрсний чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор 50 ш нунтаг сорьцонд техникийн бүрэн шинжилгээ, хийн шинжилгээ, чөмгөн дээжинд техникийн бүрэн шинжилгээ, хийн шинжилгээ, нүүрсний мацералын шинжилгээ болон витринитийн гэрлийн ойлтын зэргийг тодорхойлох шинжилгээнүүдийг хийхээр төлөвлөлөө. Лабораторийн судалгааны шинжилгээний төрөл, аргачлалуудын талаар авч үзье.

Техникийн бүрэн шинжилгээ

Нүүрсний давхраасуудын чанарын техникийн бүрэн шинжилгээг нийт 100 дээжинд /нунтаг, чөмгөн/ Австралийн “Эс Жи Эс” групп лабораторийн Улаанбаатар дахь салбар, “АЛС” лабораторийн Улаанбаатар дахь салбар лабораториудад дараах арга аргачлал стандартын дагуу тодорхойлуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 3. Техникийн шинжилгээний аргачлал

Шинжилгээний төрөл	Стандарт дугаар	Аргачлалын тайлбар
Нийт чийг тодорхойлох хоёр шаттай арга	BS 1016-104.1; ISO 11722, MNS ISO 589-2003	Эхний шатанд 3-5 кг нүүрсний дээжийг <40°C температурт хатаах шүүгээнд хатааж жингийн алдагдлыг тооцох ба хоёр дахь шатанд эхний шатанд хатаасан 10 г дээжийг <3 мм хэмжээтэй болгон нунтаглаж 105-110°C температурт 2 цаг хатааж жингийн алдагдлаар нийт чийгийн агуулгыг тодорхойлдог.
Үнслэг	BS 1016-104.1; ISO 1171; ASTM D3174	1г нүүрсний дээжийг тасалгааны температурт зуух руу хийж температурыг 30 мин-д 500°C, 30-60 мин-д 500°C-с 815°C хүртэл өсгөж энэхүү температуртаа 1 цагийн турш халааж нүүрсний шатах хэсгийг шатааж, дэгдэмхий нэгдлүүдийг зайлуулсны дараа үлдэх шатамхай бус үлдэгдлийн гарц болох үнслэгийг тодорхойлно.
Дэгдэмхий бодисын гарц	BS 1016-104.3; ISO 562 MNS ISO 562:2001; ASTM D3175	1 г нүүрсний дээжийг тигельд хийж таглаад 900±5°C-д температурт 7 минутын хугацаатай халаах байдлаар жингийн аргаар гүйцэтгэдэг ба дээжийн нийт жингийн алдагдлаас нүүрсний чийгийн агуулгыг хасаж тооцоолно.
Нийт хүхэр	ISO 19579	0,3г нүүрсний дээжийг хүчилтөрөгчийн орчинд 1300°C-н температурт шатааж нийт хүхэрийг SO ₂ хэлбэрт оруулах ба нийт хүхэрийн агуулгыг өндөр туяаны багаж болох Sulfur analyzer-р тодорхойлно.
Харьцангуй нягт	ISO 5072; GB/T 217-2008	2г нүүрсний дээжийг пикнометрт буй шингэнд живүүлж түрэгдсэн шингэний хэмжээг тодорхойлох зарчимд тулгуурлана.

Шинжилгээ- ний төрөл	Стандарт дугаар	Аргачлалын тайлбар
Илчлэг	ISO 1928, GB/T-213- 2008	1 г нүүрсний дээжийг калориметрийн бортгонд хүчилтөрөгчийн орчинд бүрэн шатааж ялгарах дулааны хэмжээг калориметрийн багажаар тодорхойлно.
Чөлөөт хөөлтийн зэрэг	ISO 501	1 г дээжтэй тигелийг таглаад 900 ⁰ С температур хүртэл халаасан зууханд 90 сек байлгахад 800±10 ⁰ С хүртэл халаах ба дараах 150 сек-д 820±5 ⁰ С температур болж өөрчлөгдөнө.Тигельд үүссэн хатуу үлдэгдлийг стандарт дүрстэй харьцуулах замаар чөлөөт хөөлтийн зэргийг тодорхойлно.

Петрографийн судалгааны аргачлал

Бид өрөмдлөгийн цооногоос гарсан дээжинд нүүрсний мацералын шинжилгээ болон витринитийн гэрлийн ойлтын зэргийг тодорхойлуулахаар төлөвлөлөө.

Хийн шинжилгээ

Тухайн өрөмдсөн цооногудад хийн шинжилгээ хийх хэмжээний нүүрс илрэх тохиолдолд хийн найрлага болон агууламжийн шинжилгээг хийх бөгөөд чөмгөн дээжит хайгуулын өрөмдлөгөөс гарсан дээж бүрийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн.

НДМХийн хайгуулын үед цооногт илрэх нүүрсний дээжээс тухайн сав газрын хийн шинж чанар, агуулгыг тодорхойлох зорилгоор Q1, Q2, Q3 хэмжилтүүдийг хийхээр төлөвлөлөө.

Q1 буюу Lost gas нь тухайн цооногоос нүүрсний дээжийг татаж гаргах явцад болон зориулалтын канистр нүүрсний дээжийг битүүмжлэх хүртэлх алдагдсан хийн хэмжээ юм. Алдагдсан хийг шууд хэмждэггүй бөгөөд нүүрсний дээжийг өрмийн яндангаас татаж гаргахаас эхлээд десорбцийн саванд битүүмжилсний дараа хэмжсэн хийн десорбцийн хурдаар буюу хугацааг нь тооцдог.

Q2 буюу desorption gas нь тусгай зориулалтын саванд битүүмжилсэн нүүрсний дээжийг тодорхой хугацаанд хадгалсны дараа нүүрснээс ялгарч буй хийн хэмжээг тооцоолохыг хэлнэ.

Q2 буюу residual gas буюу үлдэгдэл хийн хэмжээ нь тухайн нүүрсний дээжийг нунтаглах явцад ялгарах хийн хэмжээгээр тооцогдоно.

Тухайн хийн хэмжилтүүдийг зориулалтын хээрийн лабораторын орчинд хийлгэх бөгөөд гэрээлэгчийг сонгон шалгаруулж, туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах замаар хийлгэнэ.

ЦООНОГИЙН ТУРШИЛТ (IFOT)

Өнгөрсөн тавь гаруй жилийн туршид агуулагчийн нэвчилт болон даралт, цооногийн нөхцөлийг уламжлалт газрын тосны цооногуудад үйлдвэрлэлийн гарцад гарсан өөрчлөлтөд ажиглалт хийж тодорхойлдог байсан бол энэ аргыг нүүрсний цооногуудад мөн адил хэрэглэдэг болсон. Зарчмын хувьд ерөнхийдөө уламжлалт газрын тосны цооногтой нийцэх бөгөөд зарим нэг багахан өөрчлөлтүүдийг хийснээр нүүрсний цооногийн туршилтыг хийхэд ашиглаж болдог.

Цооногийн туршилт IFOT нь нүүрсний үеийг болон нүүрстэй цооногийг тодорхойлоход эхэндээ ашиглагддаг байсан. Цооногийн IFOT туршилт нь усаар ханасан нүүрстэй цооногт сайн хийгддэг боловч чөлөөтэй хий байгаа нөхцөлд харьцангуй нэвчилтийн үр нөлөөг үзүүлдэг. Чөлөөт хий байгаа нөхцөлд, ус шахахтай холбоотойгоор даралт ихсэхтэй зэрэг ханасан хий буурдаг.

Цооногийн IFOT туршилтын тестийг ан цавшилын параметруудийг тодорхойлох, хагас ан цавшилын урт, эсэргүүцэл, ан цавшилын эсэргүүцэл зэргийг тодорхойлдог.

1.2 Ажилчдын тоо, ажиллах горим

Тахь Ресурс ХХК нь хайгуулын талбай дээр ажиллахдаа төслийн талбайд дахь үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, удирдан чиглүүлэх бөгөөд үндсэн компаниас 4 хүртэл ажилтан ажиллана. Бид хайгуулын өрөмдлөг, катерингийн үйлчилгээг туслан гүйцэтгэгчдээр гүйцэтгүүлэх бөгөөд байнгын 18 хүн төсөл үргэлжлэх хугацаанд буюу 80 хоног ажиллахаар тооцлоо. Цооногийн геофизик болон цооногийн туршилт хийх компаниуд өрөмдлөгийн цооног хаагдсан үед богино хугацаанд ажиллах болно.

Хүснэгт 4. Ажил үргэлжлэх хугацаа болон ажиллах хүчний нэгдсэн мэдээлэл

Ажлын үе шат	Ажлын үргэлжлэх хугацаа (хоног)	Ажиллах горим	Ажилчдын тоо
Цооног өрөмдлөг	60	2 ээлжээр 24 цаг	22
Цооногийн геофизик	10	2 ээлжээр 24 цаг	32
Цооног туршилт	10	2 ээлжээр 24 цаг	32

1.3 Усны эх үүсвэр ба ус хэрэглээ

Өрөмдлөгийн үед ашиглагдах техникийн усны хэрэглээг дулааны улиралд 2023 Онд Нарийнтээл суман дахь Баянтээг уурхайн шүүрлийн уснаас авч хэрэглэх, хүйтний улиралд уурхайн тосгоны гүний уснаас авч хэрэглэхээр төлөвлөлөө. Ундны усны эх үүсвэрийг өрөмдлөгийн талбайд ойролцоох ундны усны худагаас авахаар төлөвлөлөө.

Техникийн болон ундны усны зарцуулалтыг Өвөрхангай аймгийн Байгаль Орчин, Аялал жуулчлалын газар 2022.12.15 ны өдрийн 03/12 тоот дүгнэлтийг үндэслэн тооцооллоо.

Хайгуулын үйл ажиллагаанд ашиглах 1260 м3 усны төлбөрийг “Төсвийн тухай” хуулийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлнэ.

Техникийн усны хэмжээ

Хүснэгт 5. Технологийн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ, тн

№	Ажлын төрөл	Хугацаа, хоног	Хэмжих нэгж	Ашиглагдах усны хэмжээ, тн	
				Өдөрт	Нийт
1.	Өрөмдлөг	60	тн	18	1080
2.	Цооногийн геофизик	10	тн	18	180
3.	Цооногийн туршилт	10	тн	18	180
	Нийт	80		18	1440

Унд ахуйн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ

Унд ахуйн усны хэрэгцээг тооцохдоо Монгол улсын БОНХАЯСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалын дагуу “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”-ын дагуу, худаг, булаг зэрэг уснаас зөврөөр хангагддаг гэр хорооллын ус хэрэглээний нормоор 20 л/хоног байхаар тооцов.

Хүснэгт 6. Унд ахуйн хэрэгцээнд ашиглах ус

№	Ажлын төрөл	Хугацаа, хоног	Хүн	Хэмжих нэгж	Ашиглагдах усны хэмжээ, литр	
					Өдөрт	Нийт
1.	Өрөмдлөг	60	22	Литр	20	26,400
2.	Цооногийн геофизик	10	32	Литр	20	6,400
3.	Цооногийн туршилт	10	32	Литр	20	6,400
	Нийт	80		Литр	490	39,200

Хүснэгт 7. Нийт усны хэрэглээний дүн

Д/д	Зориулалт	Хэмжих нэгж	Өдөрт	Ажлын хэмжээ /хоног/	Нийт, тн
1.	Техникийн хэрэглээ	тн	18	80	1440
2.	Ахуйн хэрэглээ	Тн	0.49	80	39.2
	Нийт		18.49	80	1479.2

Жич: Хоногт 18.49 тн ус ашиглах тооцоо гарсан байна. Иймээс Усны тухай хуулийн дагуу хоногт 50 тн-оос бага ус ашиглах тул Аймгийн байгаль орчны албаар дүгнэлтээ гаргуулж зөвшөөрлөө авна.

1.4 Химийн бодисын хэрэглээ

Тахь Ресурс компани нь өрөмдлөгийн ажлын туслан гүйцэтгэгч компани болох Топ Даймонд Дриллинг ХХК-тай гэрээтэй бөгөөд. Тус компани нь хайгуулын өрөмдлөгийн ажилд химийн бодис ашиглах зөвшөөрөлтэй бөгөөд зөвшөөрлийг цахимаар хавсаргалаа.

Хүснэгт 8. Химийн бодисын зарцуулалт

Д/д	Зориулалт	ОУ-ын нэршил	Хэмжих нэгж	Өдөрт	Ажлын хэмжээ /хоног/	Нийт, кг
1.	Өрөмдлөгийн гарцыг нэмэгдүүлэх	Cr-650	Кг	7.5	80	600
2.	Цооногийн хана бэхжүүлэгч	Corewell	Кг	7.5	80	600
Нийт				7.5	80	1200

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын төвийн хэсэгт орших НДМХ Онги-V блокын талбай нь Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Баруунбаян-Улаан, Баянгол, Тарагт, Төгрөг, Нарийнтээл, Гучин-Ус, Дундговь аймгийн Сайхан-овоо нийт 8-н сумын 21200.3 км² газар нутгийг хамарч байна.

Физик газарзүйн мужлал¹: НДМХ Онги-V блокын талбай нь баруун Алтайн уулархаг их муж, Говь-Алтайн муж, Говь-Алтайн баруун, талбайн төв ба зүүн талаар Говийн их муж, Алтайн ар говийн муж, Нууруудын хөндий, талбайн баруун хойд, хойд талаар Хангай-хэнтийн уулархаг их муж, Хангайн муж, Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрогт тус тус хамаарч байна. Нарийвчилсан хайгуул хийх талбайнуудын хувьд:

Баянтээг-1, Хөөт талбай: Бүхэлдээ Хангай-Хэнтийн уулархаг их муж, Хангайн муж, Хангайн өмнөд бэгэлцэг тойрог

Баянтээг-2, Онги талбай: Бүхэлдээ Говийн их мужийн дэд муж болох Алтайн ар говийн муж, Нууруудын хөндийн тойрог

Байгалийн бүс, бүслүүрээр² талбайн хойд талын хэсэг хуурай хээр, төвийн хэсэг нь цөлжүү хээр, урд талын хэсэг нь заримдаг цөл, баруун урд талын уулархаг хэсэг нь хээр, өндөр уулын бүсэд хамаарна. Нарийвчилсан хайгуул хийх талбайнуудын хувьд:

Баянтээг-1: Талбайн баруун хойд талын үзүүр хэсэг Хуурай хээр, баруун, зүүн, урд тал Цөлжүү хээрийн бүсэд

Баянтээг-2: Талбайн хойд, зүүн хойд тал Цөлжүү хээр, баруун, зүүн, урд тал Заримдаг цөлийн бүсэд

Хөөт: Талбай нь бүхэлдээ хуурай Хээрийн бүсэд

Онги: Талбайн баруун, зүүн хойд, хойд тал Хуурай хээр, урд болон зүүн талын хэсэг Цөлжүү хээрийн бүсэд

Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар талбайн баруун хойд талын хэсэг Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, Зүүн хойд талын хэсэг Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн муж, төвийн болон зүүн, зүүн урд талын хэсэг Дорнод говийн цөлөрхөг муж, баруун урд талын хэсэг Говийн-Алтайн уулсын муж, баруун талын хэсэг Алтайн ар говийн цөлөрхөг мужид тус тус хамаарч байна. Нарийвчилсан хайгуул хийх талбайнуудын хувьд:

Баянтээг-1: Талбай бүхэлдээ Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж

Баянтээг-2: Талбайн хойд тал Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, баруун, зүүн, урд тал Алтайн ар говийн цөлөрхөг мужид

Хөөт: Талбайн бүхэлдээ Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужид

Онги: Талбайн зүүн урд талын зурвас газар Дорнод Говийн цөлөрхөг муж, үлдсэн хэсэг нь Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужид

Уур амьсгал: Байгаль цаг уурын хувьд эрс тэс, эх газрын уур амьсгалтай, өвөлдөө хангайн бүсээр -40-43 хэм, тал хээр, говийн бүсээр -35-39 хэм хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь хангайн бүсээр 14-17 хэм, тал хээр, говийн бүсээр 18-22 хэм хүрдэг. Салхины хурд 5-8 м/сек, жилд дунджаар 265 мм хур тунадас унадаг. Өвөрхайнгай аймгийн Богд сумын хойд хэсгээр 3.5...3.8°C, бусад сумдын нутгаар 1.9...3.5°C дулаан байдаг. Тус нутгийн 1 дүгээр сарын агаарын дундаж температур Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын баруун хэсгээр -18.0 19.0°C, Өвөрхангайн Гучин-Ус, Нарийнтээл сумдын нутгаар болон Богд сумын хойд хэсгээр -15.5 16.0 °C хүйтэн байдаг бол бусад сумдаар -16.0...-18.0°C хүйтэн байдаг. 7 дугаар сарын агаарын дундаж температур Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Төгрөг, Гучин-Ус сумдын хойд хэсгээр 18.2 20.0°C дулаан, бусад нутгаар 20.0 21.8°C дулаан байдаг.

¹ Физик газарзүйн мужлалт гэдэг нь газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалшил, амьтны

аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм.

¹ Байгалийн бүс гэдэг нь Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст уур амьсгалыг бүрдүүлэгч нарны цацраг багасаж дулааны хэмжээ буурдаг учир өргөрөг бүрд байгалийн нөхцөл янз бүр болж бүсийн шинж чанартай болохыг хэлнэ. Монгол орон өндөр уулын болон уулын тайгын бүслүүр, ойт хээр, хээр, говь, цөлийн бүс гэсэн 6-н бүс, бүслүүрт хуваагддаг.

Гадаргын ус: Төслийн талбай нь ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай савын түр урсгал бүхий гол горхины мужид хамаарах ба Монгол орны усны сав газраар Таац, Онги, Алтайн-Өвөр говь, Умард говийн гүвээт халхын дундад тал гэсэн 4 усны сав газарт орж байна.

Таац голын сав газарт 1’649’182.0 га буюу 78%, Онги голын сав газарт 410’181.2 га буюу 19.4%, Алтайн-Өвөр говь 31’715.0 га буюу 1.5%, Умард говийн гүвээт халхын дундад тал 23’257.7 га буюу 1.1%-ийг тус тус эзэлж байна. Онги-V талбайд Таац голын цутгал Таацын цагаан нуур, Ар ахуйтын гол, Онги гэсэн томоохонд тооцогдох гол, нуур болон түр урсгалтай жижиг гол, булаг, шанд хамрагдаж байна.

Төслийн талбайн хамгийн том гадаргын уст цэг нь Онги гол юм. Онги голын олон жилийн дундаж өнгөрөлт Уянга сумын орчим 1.54, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын орчим 1.30 м³/с болно. Онги голын урсац 1988 оны 7 дугаар сард Уянга сумын орчимд 1.23 м³/с, Онги, Улаан голын бэлчир Арвайхээр орчимд нэмэгдэж 3.4 м³/с хүрээд Сайхан-Овоо сумын орчим ширгэсэн байна.

Газрын доорх ус: Төслийн талбайн газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь Онги гол болон зарим уул нуруудын хормой бэл газарт хуримтлагддаг байна. Талбайд нөхөн сэргээгдэх нийт нөөц нь 204.3 м³/жил, ашиглалтын баримжаат нөөц 64.1 м³/жил байна.

Хөрсөн бүрхэвч: Онги-V блокын талбайн газрын гадарга нь ерөнхийдөө бэсрэг уулс, ухаа гүвээ толгод, өргөн, нарийн хөндий, хужир марз бүхий хотгор хонхороос бүрдэнэ. Эндхийн уулс нурууд нь баруунаас зүүн, хойноос урагшаа тийшлэх тутам аажмаар намсдаг онцлогтой. Онги-V блокын талбайн хөрсний хэвшинж нь хээрийн ба хуурай хээрийн цайвар хүрэн, жинхэнэ хүрэн хөрс, уулын хүрэн, цөлөрхөг хээрийн бор хөрс дийлэнх талбайг буюу 74.5%-ийг эзлэж байна. Үлдсэн талбайд уулын хүрэн, нугын хүрэн болон цөлийн бор саарал хөрс алаг цоог байдлаар тархсан байна.

Ургамлан нөмрөг: Нутгийн хойд хэсэгт хангайн нурууны салбар уулс, төв хэсгээр нь хөндийн тал, өмнө хэсгээр нь Алтайн нурууны салбар уулс, элсэрхэг тал хээрийн нутагтай. Дундад Халхын тойрогт хамаарна. Монголын хээр нь нутгийн дорнод хэсэгт байх ба

Хянганы уулсаас баруун тийш, Хангайн уулсын өмнөд хэсгээр байрладаг, нам уул, хотгор гүдгэр, ухаа гүвээт тэгшивтэр газраар орших бөгөөд баруун тийш нарийсан явсаар их нуурын хотгорын зүүн талаар нарийн зурвас нутгийг хамаарна. Хээрийн ургамал нь уул хээрийн ургамалтай холилдон ургасан байдаг. Элдэв ургамал ховор намхан, сийрэг ургамлан нөмрөгтэй.

Амьтны аймаг: НДМХ Онги-V блокын талбайн бүс нутаг нь амьтны аймгийн газар зүйн мужлалаар Монгол-Түвдийн их муж Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол дагуурын тойрог, Говийн дэд мужийн Хойд говийн тойрогт хамаарагдаж байна. Судалгааны талбай нь Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өвөрхангай аймгийн Баянгол, Төгрөг, Тарагт, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд энэ бүс нутагт янгир, аргаль хонь, хар сүүлт зээр, саарал чоно, үнэг, хярс, мануул, бор туулай, монгол огдой, үлийн цагаан оготно зэрэг хөхтөн амьтад, шилийн сар, хээрийн бүргэд, нөмрөг тас, үлэг харцгай, өвөгт тогоруу, монгол ногтруу, хотны бүгээхэй, адууч чогчиго, шоорон эвэрт болжмор, монгол болжмор зэрэг шувууд, цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл зэрэг мөлхөгч амьтад түгээмэл тохиолдоно. Онги-V блокын талбайд 38 зүйлийн хөхтөн амьтан, 128 зүйлийн шувуу, 8 зүйлийн мөлхөгч, хоёр нутагтан, 300 гаруй зүйлийн сээр нуруугүйтэн амьтад бүртгэгджээ.

